



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн
байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд тусгагдсан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай:

1/Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг батлан мөрдүүлэх;

2/түүхий тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх;

3/төслийн барилга, бүтээн байгуулалтын үе шатанд БНЭУ-аас нийлүүлэх бараа, ажил үйлчилгээний хэмжээг бууруулж, шаардлагатай бараа материалыг хөрш орноос нийлүүлэх, дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийг төсөлд оролцох боломжийг нэмэгдүүлэх талаар БНЭУ-ын Засгийн газартай хамтран ажиллах;


4/газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга, бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бараа материалыг импортлоход учирч байгаа хүндрэлийн талаар БНЭУ, БНХАУ-ын Гадаад харилцааны яамтай ярилцаж, шийдвэрлэх;

5/Газрын тосны тухай хуульд заасны дагуу түүхий тосыг газрын тосны үйлдвэрт тэргүүн ээлжид нийлүүлэх талаар газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй гэрээ, хэлцэл байгуулах;

6/газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх замаар үйлдвэрийн түүхий эд, баталгаат нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх, үүнтэй холбогдон гарах хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо /Г.Тэмүүлэн/-нд даалгасугай.

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Б.ЧОЙЖИЛСҮРЭН